



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 0/303

Улаанбаатар хот

Нэг удаагийн буцалтгүй тусламж
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.2.2 дахь заалт, Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2021-2022 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээний 6.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өөрийнх нь хүсэлтийг харгалзан Зуухан цехийн Ашиглалтын хэсгийн Ээлжийн дарга Даваахүүгийн Дорждан нь анх гэр бүл болсонтой нь холбогдуулан 672,000 (Зургаан зуун далан хоёр мянга)-н төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2.П.Доржданд нэг удаагийн буцалтгүй тусламж болох 672,000 (Зургаан зуун далан хоёр мянга)-н төгрөгийг тооцон олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий Нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ